

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

БАТЛАВ.

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

"БАЯНТЭЭГ" ХК-ИЙН ЗАХИРАЛ Ц.БАЗАРРАГЧАА



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН
НУТАГТ ОРШИХ БАЯНТЭЭГИЙН НҮҮРСНИЙ
УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000367

ХЯНАСАН:

БОУАӨЯ-НЫ ХБӨБХГ-ЫН

МЭРГЭЖИЛТЭН:

Ч.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

"БАЯНТЭЭГ" ХК-ИЙН ХАБЭАБО ХЭЛТЭС,
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАЯРСАЙХАН

АГУУЛГА

Оршил	3
БҮЛЭГ 1. Төслийн танилцуулга.....	4
1.1 Уурхайн байршил	5
1.2 Уурхайн ажиллах горим	5
1.3 Уулын ажлын төлөвлөгөө.....	5
1.4 Усан хангамж, усны хэрэглээ	6
1.5 Цахилгаан хангамж.....	6
БҮЛЭГ 2. Төслийн талбай орчмын байгаль орчин, нийгмийн төлөв байдал, онцлог	7
БҮЛЭГ 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
3.1 Экосистемин бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал	8
3.2 Байгалийн баялаг, нөөц ашиглалт.....	9
3.3 Байгаль орчны чанарын өөрчлөлт.....	9
3.4 Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор	10
3.5 Нийгэм, эдийн засаг	10
3.6 Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл	10
3.7 Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал	11
БҮЛЭГ 4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	12
БҮЛЭГ 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
БҮЛЭГ 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
БҮЛЭГ 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	17
БҮЛЭГ 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ..	18
БҮЛЭГ 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
БҮЛЭГ 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
БҮЛЭГ 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	21
БҮЛЭГ 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
БҮЛЭГ 13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	25
БҮЛЭГ 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Баянтээгийн уурхайн фото зураг	4
Зураг 2. Уурхайн байршлын зураг	5

ОРШИЛ

Энэхүү менежментийн төлөвлөгөөнд “БАЯНТЭЭГ” ХК-ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт хэрэгжүүлж буй Баянтээгийн нүүрсний орд төслийн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө нарийвчлан тусгагдсан.

Баянтээгийн нүүрсний ордын төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол улсын хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, нэмэлт тодотголуудад тусгасан заалтууд болон судалгаа шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын өгсөн зохих дүгнэлт, заавар зөвлөлгөөг удирдлага болгон боловсруулсан болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт олборлолтын явцад ус, хөрс, агаарт гарч болзошгүй нөлөөлөл, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд орох аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болон хэмжилт хийх цэгийн байршил, шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах хэлбэр зэргийг тусгасан.

Уг төлөвлөгөөнд тухайн төсөл хэрэгжих орчмын өнөөгийн төрх байдал, БОННУ-гээр тодорхойлогдсон болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг тусгаснаас гадна менежментийн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд болох дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, түүх соёлын өв, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэргийг дэлгэрэнгүй авч үзсэн.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Баянтээгийн нүүрсний уурхайн 1962-1978 онуудад олборлосон нөөцийн хөдөлгөөнийг 1978 оны ордод хийгдсэн нарийвчилсан хайгуулын ажлын тайланд тусгасан бөгөөд нийтдээ 771.0 мянган тонн нүүрс олборлосон гэж тэмдэглэжээ. Олборлолтын явцад нэмэгдсэн нүүрсний нөөц 801.0 мянган тонн, нөөцийг нь батлагдаагүй талбайгаас 88.2 мянган тонн нүүрс олборлосон нь тооцооллоор тодорхой болсон. Нийтдээ 1962-2023 онуудад Баянтээгийн уурхай 6.18 сая тонн нүүрсийг олборлон борлуулжээ. Уурхайн нийт гүн 39 м болсон байна. Уулын ажлыг олон жилийн турш нүүрсний гарш хэсгийн дагуу нийтдээ 5.4 км урттайгаар явуулжээ.




Зураг 1. Баянтээгийн уурхайн фото зураг

Төслийн нэр	“Баянтээг”-ийн нүүрсний ордыг ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Баянтээг” ХК
Регистрийн дугаар	2014491
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Өвөрхангай аймаг, Нарийнтээл сум, Баянтээг 2-р баг, өөрийн байр Утас: 89490008, 98995110, 88441878
Ашиглалтын ТЗ дугаар	MV-000367
Талбайн хэмжээ, га	581.74 га

1.1 УУРХАЙН БАЙРШИЛ

“Баянтээг”-ийн нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос баруун урагш 560 км, Арвайхээр хотоос баруун урагш 128 км, Нарийнтээл сумын төвөөс 45 км, Өвөрхангай-Баянхонгор чиглэлийн хатуу хучилттай замаас 22 км, Баянтээг багийн төвөөс урагш 300м зайд байрлана.



Зураг 2. Уурхайн байршлын зураг

1.2 УУРХАЙН АЖИЛЛАХ ГОРИМ

2024 онд манай уурхай 04 сараас 10 сар хүртэл хөрс хуулалт хийж, нүүрс олборлолтыг 1-12 дугаар саруудад буюу жилийн турш олборлон борлуулна. Уурхай нь МУ-ын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн дагуу жилийн амралт, баяр ёслолын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд ажиллана.

Жилд ажиллах хоногийн тоо: 365 хоног

- Ажлын өдрүүд – 248 хоног
- Амралт баяр ёслол -117 хоног

1.3 УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Баянтээгийн уурхай нь жил бүр хөрс хуулалт ба нүүрс олборлолт нь өсөлттэй байна. Өмнөх онуудын нүүрс олборлолтын тооцоонд үндэслэн 2024 онд тус уурхай 800.0 мян.м³ хөрс хуулан 230.0 мян.тн нүүрс олборлож ажиллана.

1.4 УСАН ХАНГАМЖ, УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Уурхайн ахуйн ундны усыг Баянтээг 2-р багийн төвд 2010 онд гаргасан гүний худгаас, халаалтын усыг уурын зуухны худгаас, зам талбайн усалгааг уурхайн шүүрлийн усны эх үүсвэрүүдээс тус тус хангадаг.

Уурхай жилд өөрийн ажилтан 50 хүнээр тооцоход 250.0 м^3 , зам усалгаа 120 хоногт 9000 м^3 , уурын зуух 240 хоногт 96 м^3 , ногоон байгууламжийн усалгаа жилд 8208.0 м^3

1.5 ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Тус нүүрсний уурхай нь “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” компаний эрчим хүчний 110 кв-ын дамжуулах сүлжээнд 2005 оны 05 сард 110/35/10 кв-ын Баянтээг дэд станц холбогдсон ба эндээс өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар уурхайн хэрэгцээг хангаж байна.

Тус уурхайн ЭКГ-5А экскаватор 6 кв-ын , СВБ-2М төрлийн өрмийн машин 1 ширхэг бусад жижиг хэрэглэгчид байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ

Баянтээгийн нүүрсний уурхайн төслийн талбайд байгаль орчны төлөв байдлын судалгааг 2020 онд байгаль орчны судалгаа үнэлгээний “Мэнд шүтээн” ХХК гүйцэтгэсэн. Тус судалгааны ажлын хүрээнд гаргасан гол үр дүнгүүдийг дор дэлгэрүүлэн авч үзэв.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг 2020 батлуулсан бөгөөд төслийн нөлөөллийг тодорхойлсон хүснэгтээс үзэхэд нийт нөлөөллийн 20% нь хүчтэй, 45% нь дунд зэрэг, 35% нь бага эрчимтэй байна.

Тухайн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөл учруулах боловч улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэж, багийн иргэдийг ажлын байраар хангаж байгаагаас гадна Өвөрхангай аймгийн төв ба бусад ойролцоох хэд хэдэн аймаг сумдын нүүрсний хэрэгцээг хангаж байгаа чухал ач холбогдолтой төсөл юм.

Төслийн үйл ажиллагаанаас экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт, байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг энэ хэсэгт хамруулсан.

Тус төсөл хэрэгжсэнээр MV-000367 тоот тусгай зөвшөөрлийн 581.7 га талбайн 471.5 га шууд нөлөөлөлд өртөнө. Шууд бус нөлөөллийн бүсийг тоосжилтын тархалтын хамгийн их агууламжын хүрээгээр тодорхойлсон бөгөөд шууд бус нөлөөллийн талбай уурхайгаас 2030 м буюу 6974 га байна. Өөрөөр хэлбэл энэ хэмжээний байгалийн бэлчээр шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх боловч уурхай 1962 оноос хойш олон жилийн үйл ажиллагаа явуулж байгаа тул нутгийн иргэд уурхайн үйл ажиллагаатай дасан зохицож мал аж ахуй эрхлэн амьдарсаар байна.

3.1 ЭКОСИСТЕМИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮДЭД НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Баянтээгийн нүүрсний уурхай нь одоогийн байдлаар 61 га талбай бүхий 4.8 км урт, 150 м өргөн, 10-20 м гүнтэй ухааш үүсээд байна. Ашиглалтын 60 гаруй жилийн хугацаанд 5.4 км урт, 530 м өргөн, 100 м гүн ухааш үүсэх бөгөөд нийт хугацаанд 98.8 сая.м³ хөрс хуулж, 26004.3 мян.тн нүүрс олборлоно.

Цаашид одоогийн ил уурхайн ухашийн хил хүрээ тэлж, 90 м-ээр гүнзгийрнэ. Ордын газрын доорхи ус нь 1.5-36.5 м-ийн гүнээс шүүрэх бөгөөд одоогийн байдлаар 5.3 л/сек ус шүүрч байна. Урьдчилсан тооцоогоор төслийн

хугацаанд нийтдээ 69.7 сая.м³ ус шүүрэх ба ус шавхан зайлуулалтаас газрын доорхи усны түвшин, нөөц буурна.

Мөн удаан хугацаагаар газрын доорхи усыг шавхан зайлуулснаас газрын доорхи усны горимд өөрчлөлт орж болзошгүй. Олборлолтын ажлын технологи нь өрөмдлөг-тэсэлгээ, ухаж ачих, тээвэрлэх гэсэн процессуудаас бүрдэнэ. Иймд газрын хэвлийн нөөц баялгийг ашиглах явцад бий болох ихэнх нөлөөлөл нь шууд нөлөөлөлд хамаарна.

Ашиглалтын хүчин чадал бага (жилд 70.0- 500.0 мянган тн нүүрс олборлоно) боловч тухайн орон нутгийн байгаль-экоосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, бэлчээрийн ургамалд шууд нөлөөлж буй эдгээр нөлөөлөл нь урт хугацааны дунд хүчтэй нөлөөлөлд хамрагдах бөгөөд ихэнхдээ буцалтгүй шинжтэй байна. Түүнчлэн тоос шороо дэгдэн бичил уур амьсгалын нөхцөл богино хугацаагаар бага зэрэг өөрчлөгдөж болох юм.

3.2 БАЙГАЛИЙН БАЯЛАГ, НӨӨЦ АШИГЛАЛТ

Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй юм. Иймд Монгол улсын Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд түүнийг сорчлон ашиглахыг хориглоно. Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

3.3 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТ

Тус уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд одоогийн байдлаар уурхайн ашиглалтын 5 м давхаргаас гүний ус шүүрч байгаа учир шатах тослох материал, тэсрэх бодисын хэрэглээ, хог хаягдал зэрэгтэй холбоотойгоор хөрс бохирдсон тохиолдолд, мөн шүүрлийн усыг бохирдуулснаар газрын доорх усны чанарт өөрчлөлт орж болзошгүй бөгөөд энэ нөлөөлөл нь урт хугацаанд /газрын доорх усанд нэвчсэн шатах тослох материалын задрал удаан байна/, буцалттай /задрал удаан боловч тодорхой хугацааны дараа ус цэвэрших боломжтой/, бохирдсон газрын доорхи уснаас мал, амьтан, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үр дагавар нь дунд зэрэг учир эрчим нь дунд зэрэг байна.

Тэсэлгээний процессоос агаарт ялгарах хамгийн их тоосонцорын агууламж 1783.84 мкг/м³ байх бөгөөд нөлөөллийн эрчим нь дунд, богино хугацаанд сарнина, уурхайн ухаш, гадаад овоолгоос үүсэх тоосонцорын агууламж 50 м зайд 91-92 мкг/м³ бөгөөд нөлөөллийн эрчим дунд зэрэг байгаа ба эдгээр нөлөөлөл нь урт хугацаанд, буцалтгүй нөлөөлнө. Тэсрэх бодисын ашиглалттай холбоотой хүний эрүүл мэндэд /тэсрэх бодистой харьцаж байгаа ажилчид/ сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай /эрсдэлийн үнэлгээний хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү/.

3.4 БАЙГАЛИЙН ӨНГӨ ТӨРХ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛ, АРХЕОЛОГИ, ПАЛЕНТОЛОГИЙН ОЛДВОР

Байгалийн тогтоц буюу газрын гадаргын хэлбэршилд сөрөг нөлөөлөл үзүүлэх бөгөөд 100 м гүн, 5.4 км урт, 530 м өргөн ухаш; 60 м өндөр, 113625.1 мян.м³ эзэлхүүнтэй, 235.6 га талбай бүхий хөрсний овоолго үүсэх бөгөөд энэ тухайн нутгийн байгалийн унаган дүр төрх, ландшафтыг хүчтэй өөрчлөлтөнд оруулна. Тус ордын нутаг орчим тусгай хамгаалалтай газар нутаг байхгүй.

3.5 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

Ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаа нь улс, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулахаас гадна 43-100 гаруй хүнийг ажлын байраар хангах ба ажлын байр нэмэгдэх нь тэдний амьжиргаанд тус нэмэр болж буй сайн талтай юм. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны эерэг нөлөөлөлд хамаарна.

3.6 ТӨСЛИЙН БАЙРШИЛТАЙ ХОЛБООТОЙ НӨЛӨӨЛӨЛ

Тус нүүрсний уурхай нь хуурай хээрийн экосистем бүхий нутагт, цөлжилтөнд нэрвэгдэж болохуйц нутагт байрлах тул нүүрс олборлох технологийн бүхий л үе шатанд тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхээс болгоомжлох шаардлагатай. Хуурай хээрийн бүс нутагт ил аргаар ашигт малтмал олборлодог уурхайн хувьд онц аюултай хүчтэй салхи, уруйн үер (аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай. Уурхайгаас олборлосон нүүрсийг хатуу хучилттай зам хүртэл 22 км шороон замаар явдаг. Авто тээврийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020 стандартыг баримтлан ачилт хийж байна. Шороон замаар тээвэрлэлт хийх явцад агаар орчинд тоос

дэгдэх, хөрс элэгдэл, эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөтэй. Иймээс нүүрс тээвэрлэлтийн тус замыг засч сайжруулах, засмал эсвэл хайрган хучилттай болгож, цаг тухай бүрд нь засвар арчилгаа хийж байх хэрэгтэй. Мөн задгай тэвштэй машинаар нүүрс тээвэрлэх, салхи ихтэй үед ачиж, тээвэрлэхэд нүүрсний жижиг ширхэгтэй хэсэг агаарт дэгдэж орчны агаар, хөрс, ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлнэ. Уурхайн талбайн орчимд ой мод, гол, горхи, булаг шанд байхгүй. Багийн төвийн гүний худгаас ундны усны хэрэглээг хангана.

3.7 ТӨСЛИЙН ШИЙДЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ХОЛБООТОЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ

Баянтээгийн нүүрсний орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг Монгол улсын Ашигт Малтмалын Газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар баталгаажуулан ил аргаар олборлож байгаа нь технологийн хувьд хамгийн оновчтой хувилбар гэж үзсэний баталгаа болох юм. Мөн БОННУ-ний тайлангийн эрдслийн үнэлгээний хэсэгт тодорхойлсон аюул ослын үнэлгээний үр дүн, Монгол улсын хууль эрхзүйн баримт бичгийн заалт бүрийг хангаж ажиллах хэрэгтэй. Шүүрлийн усыг ил уурхайн ёроолын зумфад хуримтлуулан газрын гадаргад ил задгай асгадаг ба 300 м³/цаг хүчин чадалтай 1Д315 – 500 – УХЛ31 маркийн насосоор татаж байгаа нь өнөөгийн байдалд зохицож байна. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал: Тус уурхайн олборлолтын үйл ажиллагаанд тэсрэх бодис, тээвэрлэлт, тээврийн хэрэгсэлд ШТМ ашиглана. Тэсэлгээний материалын хадгалалт хамгаалалтанд онцгой анхаарал тавих, түүнчлэн тэсэлгээ хийх, шатах тослох материалыг хадгалах, ашиглах явцад үйлдвэрлэлийн осол аваараас сэргийлэх, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж байх шаардлагатай болно. Ахуйн хог хаягдлыг устгах, ариутгах зэрэг ажлыг тодорхой хуваарийн дагуу хийж, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж байх нь зүйтэй юм.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт нь тухайн менежментийн төлөвлөгөөний жилд авч хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллүүд, бууруулах арга зам, тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрхзүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахад оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд шууд ба шууд бус байдлаар үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, сөрөг үр дагаврыг хэрхэн хянах, илрүүлэх менежментийн арга хэмжээг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-аар хянуулж батлагдсаны дараах хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг “Баянтээг” ХК хүлээнэ.

БОУАӨЯ нь тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгож, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана.

БОМТ-ний хэрэгжилтэнд тухайн аймаг, сум, багийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, БОУАӨЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар						
1	Хатуу хучилтгүй замаар тээврийн хэрэгсэл зорчиж тоосжилт үүсэх	Пүүнээс карьер орох замыг автогрейдэрээр зам засах усалгаа хийх	Уурхайн талбайн хэмжээнд	Ү/а-ны зардалд тусгасан	тогтмол	MNS 4585:2007 MNS 5885:2000
2		Засаж сайжруулсан замаар зорчих, шинээр зам үүсгэх шаардлагатай тохиолдолд газар хөндөх зөвшөөрлийн маягтыг бөглөж шаардлагын дагуу ажиллах.				
3		Машины явах дээд хурдыг тогтоож өгөх, уурхайн хүнд даацын тээврийн хэрэгслүүд зорчих замыг сайн арчилах, замын усалгааг тогтмол хийх, ачааг заасан хэмжээнээс давуулж ачихгүй байх				
Гадаргын ба газрын доорхи усны нөөц						
4	Уурхайн захиргаа, уурхайн ажилчдын хотхоны бохир усыг түр хуримтлуулах, тээвэрлэх явцад алдагдан газрын хэвлий улмаар газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Уурхайн захиргаа, уурхайн ажилчдын суурингаас гарах хаягдал усыг, хаягдал ус хуримтлуулах танканд түр хадгалан бохир ус цэвэрлэх байгууламжид хуваарийн дагуу тээвэрлэн хүргэж механик цэвэрлэгээ хийлгэх	Уурхайн талбайн хэмжээнд	Ү/а-ны зардалд тусгасан	тогтмол	Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль
5	Ил уурхайн ус шавхалтаас шалтгаалан Газрын доорх усны түвшин доошлох	Ил уурхайгаас шүүрэх усыг шавхан зайлуулах ба уг усыг технологийн хэрэгцээнд ашиглах ба илүүдэл усыг холбогдох стандарт нийцүүлэн байгальд хаях				Хаягдал ус. Ерөнхий шаардлага (MNS:4943:2015)
6		Газрын доорх усны мониторингийн ажлыг тогтмол хийх.				
7	ШТМ алдагдаж гадаргын усыг бохирдуулах	Уурхайн ШТС, засварын газар зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, ШТМ алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг саармагжуулах				Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм MNS 4628:1998 Шатахуун түгээх станц,

8		Шатах, тослох материалыг стандартын шаардлага хангасан, зориулалтын сав, агуулахад хадгалах; алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж төлөвлөсөн байх				Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч болон газрын гадарга хэвлий						
9		Олборлолт явуулах, хөрс хуулах, хаягдлын сан байгуулах зэргээр газрын хэвлийг хөндөх үйл ажиллагааны өмнө өнгөн хөрсийг зохих хэмжээгээр хуулж овоолго хийх	Уурхайн талбайн хэмжээнд	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	Үйл ажиллагааны туршид	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
10	Гадаргын хэлбэр өөрчлөгдөх, бохирдох	Засварын газрын ойр орчимд асгарсан тос маслыг хөрснөөс хуулж цэвэрлээд дараагаар нь өөрийн шимт хөрсөнд тохирсон бор шороо, хайрга зэрэг асгаж хөрсний бохирдлыг хамгаалах		500.000	Үйл ажиллагааны туршид	MNS 5850:2019
11		Шинээр овоолго үүсгэсэн талбайд самбар байршуулах.		1.000.000	2024 онд	MNS 5915:2008
12	Ажилчдын хотхон болон уурхайн талбайд хог хаягдлыг замбараагүй хаях, хөрс бохирдуулах	Ажилчдын хотхон болон уурхайн ахуйн хог хаягдалын цэг дээр нэмж ангилан ялгалтын хогийн савууд байршуулах.	Кемп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан.	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль, журам
Ургамлан нөмрөг						
13	Хөрс хуулалт, нүүрс болон хөрс ачих, буулгах, мөн тээвэрлэх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах	Уурхайн дотоод замын усалгааг тогтмолжуулах, зориулалтын бус замын хөдөлгөөнийг хориглох, тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоох	Уурхайн талбайн хэмжээнд	Дотоод зардлаар	тогтмол	Ургамал хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
14		ОХШХ-т тусгагдсанаар ургамлын мониторингийн ажлыг тогтмол хийж гүйцэтгэх		ОХШХ-ийн зардалд тусгагдсан		
Ан амьтан						
15	Нүүрсний ордын талбайн ойр орчим амьтдын амьдрах орчин хумигдах, хоол тэжээл багасах	Баянтээг багийн төвөөс 20 км зайтай Өшгөг хайрханд хужир, шүү уст цэгүүдэд зэрлэг амьтдын амьдардаг гол тархац газарт тавьж өгөх	Уурхайн нөлөөллийн бүсэд	500.000	2024 онд	Амьтны тухай хууль

16		Шилийн сар, шонхор зэрэг махан идэшт шувуудын үүр оромж, ангуучлах нутаг, тэдгээрийн идэш тэжээл бологч амьтдын элбэгшил, байршил нутаг зэргийг харгалзан хиймэл үүр барьж өгөх		250.000		
17	Тээврийн хөдөлгөөн, дуу чимээнээс амьтдын шилжилт хөдөлгөөн багасах	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах дуу чимээний түвшинг үйлдвэрлэгчээс өгсөн хягаарт барих, засвар үйлчилгээг тогтмол хийх		Ү/а-ны төлөвлөгөөнд тусгагдсан	2024 онд	
	Нийт	Сөрөг нөлөөллийг бууруулах	арга	хэмжээний	төлөвлөгөөний	зардал, төг
		2.250.000				

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Хөрс хуулалтад өртөх, овоолгод дарагдах талбайн шимт хөрсийг стандартын дагуу хадгалах	Мян.м³	1.0	-	БО-ны зардалд тусгасан.	Жилийн үйл ажиллагааны туршид	MNS 5916:2008 MNS 5917:2008
2		Гадаад хөрсний овоолгын гадаргууг стандартын дагуу 350 налуулан тэгшлэх	Мян.м³	1.9	-			
3	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгын гадаргууд олон наст ургамлын үр цацах, тарих	га	1.0	-	2.000.000		
4		Нөхөн сэргээлт дүйцүүлэн хамгаалахад олон төрлийн мод суулгац тарих						
	Нийт	Нөхөн сэргээлтийн зардал, төг						

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Төслийн талбайн ойролцоо орших Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт бичил уул уурхайн улмаас эвдэгдсэн газар болон булаг шандын эхийг хамгаалах техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийснээр байгалын унаган төрхийг сэргээх орчинг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.	Дэрсэнэ булгийн эхийг хашиж хамгаалах	Дүйцүүлэн хамгааллын байршлыг тогтоохдоо тухайн нөлөөлөлд өртсөн “сав газар” эсвэл “экологийн бүс” –ийн хүрээнд байх зарчмыг баримталан Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт хийнэ.	20.000.000	2024 онд	Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоол. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 А/618 тушаалаар баталсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам. БОННУ-ний тайлан.
Нийт		Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал, төг			20.000.000	

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ашигласанаар материаллаг болон эдийн засгийн шилжилт үүсдэг. Материаллаг шилжилт гэдэг нь айл өрх, тэдний өмч хөрөнгө (өвөлжөө, бууц, худаг), эзэмшлийг нүүлгэн шилжүүлэхийг хэлэх бөгөөд төслийн талбайгаас 500 м дотор амьдардаг айл өрхүүдийг нүүлгэх үйл ажиллагаа юм.

Эдийн засгийн шилжилт гэдэгт айл өрхүүд, тэдний мал сүрэг хуучин бэлчрээсээ, худаг уснаасаа алслагдаж нүүхийг хэлнэ. Баянтээгийн нүүрсний төсөл хэрэгжүүлж буй талбай айл өрх, тэдний эд хөрөнгө байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Баянтээг” ХК-ийн нөлөөллийн бүсэд одоогийн байдлаар түүх соёл, археологи, палеонтологийн дурсгалууд илрээгүй. Хэрэв илэрсэн тохиолдолд Археологийн хүрээлэн. Утас: 11-452894, Факс: 11-452894, email: archaeology@mas.ac.mn Палеонтологийн хүрээлэн. Утас: 70118283, Факс: 11-325835, email: paleo@mas.ac.mn хаягуудаар шуурхай холбоо барьж мэдэгдэн хамтран ажиллана.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Археологийн дурсгал	Палеонтологи, археологийн олдвор буюу соёлын дурсгалт зүйлийн талаар баримтлах журмыг үндсэн болон гэрээт ажилчдад танилцуулж сургалт зохион байгуулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Уурхайн нөлөөллийн бүс	500.000	Жилд 1 удаа	Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2014
2.	Палеонтологийн дурсгал					
	Нийт	Түүх , соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал, төг				500.000

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Авто машин тээврийн хэрэгслийн осол гарахаас сэргийлэх	Уурхайн хувьд аливаа осол аваариас сэргийлэх зорилгоор онцгой анхаарах газруудад авто замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах, сайжруулах	Уурхайн талбайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны туршид	Авто замын тухай хууль
2.		Тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж үзлэг, засвар, үйлчилгээг тогтмол явуулах				
3	Налуугийн нуралт үүссэнээр уурхайн ажилчид бэртэж гэмтэх	Байнгын хяналт тавих, Осол гарсан үед хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах			Тайлант хугацаанд	- Гамшгаас хамгаалах тухай хууль, - Аюулгүй ажиллагааны журам, - Аж ахуй нэгж байгууллагын дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм, - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль,
4	Эх үүсвэрүүдээс их хэмжээний тоос гарах	Хуурай улиралд усны машинаар замыг тогтмол шүрших			Үйл ажиллагааны туршид	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - Агаарын тухай хууль
5	Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэлд өртөх	Байгалийн гэнэтийн аюултай үзэгдлээс учрах эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах			Үйл ажиллагааны туршид	-Гамшгаас хамгаалах тухай хууль
	Нийт	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал, төг				

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ахуйн гаралтай хатуу хог хаягдал : Ахуйн хог хаягдлыг (цаас, баглаа боодлын хайрцаг, хуванцар сав, металл, төмөр, шил, нийлэг материал г.м) ангилан түр хадгалах хогийн сав, цэгт цуглуулахаар бэлдэж, цуглуулж хэвших. Ахуйн болон бусад хатуу хог хаягдлыг ангилсаны дараагаар дахин ашиглах хатуу хог хаягдлыг тээвэрлэн хоёрдогч түүхий эд авдаг төвлөрсөн цэгт нийлүүлнэ. Ашигласан тосолыг битүүмжлэл сайтай ган саванд цуглуулан дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ. Бусад хатуу хог хаягдлыг ялган, зориулалтын саванд цуглуулан, тээврийн хэрэгслээр зөөж тогтоосон цэгт хаяна.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлын гэрээг шинэчлэн хийх	Уурхайн талбайн хэмжээнд	Ү/а-ны зардалд тусгасан.	2024	Хог хаягдлын тухай хууль 2017
2		Ахуйн гаралтай хог хаягдлын цэг дээр нэмж ангилан ялгах хогийн савууд нэмж байршуулах		1.000.000		
3	Аюултай	Аюултай хог хаягдлыг энэ чиглэлээр тусгай зөвшөөрөл бүхий компанид хүлээлгэж өгөх, гэрээ хийх		Ү/а-ны зардалд тусгасан.	Жилийн Үйл ажиллагааны туршид	
4		Аюултай хог хаягдлын бүртгэлжүүлж хадгалалт тээвэрлэлтэнд тавих хяналтыг сайжруулах			2024	
5		Холбогдох маягтын дагуу хог хаягдлыг бүртгэх, тайлагнах			Улиралд 1 удаа	
6		Хог хаягдлын цэгийн талбайд үзлэг шалгалтыг тогтмол хийх, сайжруулах, цэвэрлэх				
	Нийт	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал, төг				

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
1	CO ₂ , NO ₂ , SO ₂ , Тоос (PM10, PM2.5) Дуу чимээ, доргио Цацраг идэвхит бодис	Хяналтын цэг Ил уурхайн салхины чиглэлийн доор Уурхайн тосгон Ажлын байр Карьерын дотор дээд, дунд, доод хэсэг	Жилд 2 удаа	45.000	630.000	MNS 4585:2007 MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
2	Автотээврийн хэрэгслийн яндангийн хаягдал утаанд хэмжилт хийх	Уурхайд ашиглаж буй бүх автомашины янданд	Жилд 1 удаа	20.000	1.000.000	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
Хөрсөн бүрхэвч						
3	Хөрсний механик бүтэц, Хими физикийн шинж чанар, Хүнд металл Микро элементүүд	Хяналтын цэг, засварын газар Хог хаягдлын цэг ШТМ-ын агуулах, тосгон Шимт хөрсний овоолго Ил уурхайн дээд, дунд, доод хэсгээс	Жилд 2 удаа	160.000	2.240.000	MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005
Усан орчин						
4	Худаг, шүүрлийн усанд бактериологи, анион, катион, хүнд металл, микроэлементүүд	Баянтээг багийн төвийн худаг , Уурын зуухны худаг , Дэрсэн худаг , Шүүрлийн ус Мониторингийн цооног /шинээр байгуулна/	Улиралд 1 удаа	158.900	3.178.000	MNS 900:2005. Ундны усны чанарын стандарт
Ургамлан нөмрөг						
5	Зүйл, бүрхэц, бодьгалын тоо, дундаж өндөр, биомасс, нөхөн сэргээлтэнд тохиромжой ургамлыг сонгох	Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээнд	Жилд 1 удаа	1.000.000	1.000.000	Ургамлын тухай хууль MNS 6191:2010 MNS 3474 : 2003
Амьтны аймаг						
6	2-нутагтан, мөлхөгчид, шувууд, хөхтөн том, жижиг амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, тоо толгой (нягтшил) , Тархалт, Байршил нутаг , Шилжилт хөдөлгөөн, Амьдрах орчны ажиглалт	Тусгай зөвшөөрөлтэй талбай болон төслийн нөлөөллийн талбайн хэмжээнд	Жилд 1 удаа	1.000.000	1.000.000	Амьтны тухай хууль, Ажиглах болон дээж талбайн тооллого

	Нийт	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал, төг	9.048.000
--	------	---	-----------

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БаянтээгХХК нь Баянтээг нүүрсний уурхайн 2024 оны БОМТ-ний хэрэгжилтийн явцыг энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан БО-ны бүрдэл хэсэг тус бүрээр гаргаж, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ЗДТГ/байгаль орчны хяналтын улсын байцаагч болон Нарийнтээл сумын Баянтээг багийн иргэдийн төлөөлөлд (төслийн талбайд ойр оршин суух малчид)-д жилд 1 удаа тайлагнана. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнана. 2024 онд төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
---	---	------------------	--------------------	--------------------------------	-----------------------	---	------------------------

хуваарийг доорх хүснэгтэд үзүүлэв.

1	Нарийнтээл сумын ЗДТГ, БО-ны байцаагчид	Танилцуулга, тайлан гаргаж хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	1.000.000	БО-ны мэргэжилтэн, Орон нутагтай харилцах асуудал эрхэлсэн менежер	Нарийнтээл сумын ЗДТГ
2	Баянтээг багийн хурал						Нарийнтээл сумын ЗДТГ/багийн төвд
3	Иргэдийн төлөөлөл (Төслийн талбайтай ойролцоо нутагладаг Баянтээг багийн малчин өрхүүд)						Уурхайн талбайд/Багийн төвд
	Нийт	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах зардал, төг 2.000.000					

БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ТӨСӨВ

№	БОМТ-ний төрөл	Хэмжих нэгж	Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Төгрөг	2.250.000
2	Нөхөн сэргээлтийн зардал	Төгрөг	2.000.000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төгрөг	20.000.000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Төгрөг	-
5	Түүх , соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Төгрөг	500.000
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Төгрөг	-
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Төгрөг	1.000.000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Төгрөг	9.048.000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	Төгрөг	2.000.000
10	Нийт	Төгрөг	36.798.000